



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/114/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Р.ЦЭЦЭГМАНДАХ ТАНАА**

2025.02.16 № 34

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 119,105.0 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн балансаас баланст хөрөнгө шилжүүлсэн авсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 471,256.0 төгрөгөөр өсжээ. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

4826050114

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 91.5 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	137,279,348.61	131,939,457.28	
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	137,279,348.61	131,939,457.28	
31210	Төгрөг	137,279,348.61	131,939,457.28	
31211	Төрийн сангийн харилцах	130,253,088.07	131,939,457.28	
31218	Ахмадын сангийн харилцах	7,026,260.54	-	
33	АВЛАГА	3,645,142.00	10,251,142.00	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	559,658.00	559,658.00	
33101	Цалингийн авлага	559,658.00	559,658.00	
33500	Бусад авлага	3,085,484.00	9,691,484.00	
33510	Байгууллагаас авах авлага	-	6,606,000.00	
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,085,484.00	3,085,484.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	124,361,505.48	162,943,912.60	
35100	Түүхий эд материал	12,332,497.93	18,943,375.93	
35110	Тусгай зориулалттай материал	12,332,497.93	18,943,375.93	
35400	Хангамжийн материал	112,029,007.55	144,000,536.67	
35410	Бичиг хэргийн материал	10,673,775.52	10,723,575.52	
35420	Аж ахуйн материал	89,973,866.99	113,719,776.99	
35450	Барилгын засварын материал	2,543,000.00	3,589,000.00	
35460	Хүнсний материал	3,745,950.00	4,369,800.00	
35470	Бусад хангамжийн материал	5,092,415.04	11,598,384.16	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	265,285,996.09	305,134,511.88	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,336,800,157.65	6,808,055,948.08	
39200	Биет хөрөнгө	6,264,880,157.65	6,736,135,948.08	
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,393,814,983.90	7,053,640,396.90	
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(484,359,596.68)	(615,252,579.25)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,535,000.00	35,890,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(27,319,333.47)	(30,956,500.17)	
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	292,917,929.53	301,014,585.53	
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(83,761,587.60)	(117,086,486.31)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	204,334,069.17	223,970,554.17	
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(92,595,477.11)	(118,701,611.30)	
39217	Номын фонд	8,314,169.91	3,617,588.50	
39300	Биет бус хөрөнгө	71,920,000.00	71,920,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	71,920,000.00	71,920,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	6,336,800,157.65	6,808,055,948.08	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	6,602,086,153.74	7,113,190,459.96	
41	БОГИНО ХУГАЦААТ ОР ТӨЛБӨР	137,006,212.50	62,095,888.66	
41300	Өглөг	137,006,212.50	62,095,888.66	
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	20,274.00	
41313	ХАОАТ-ын өглөг	-	20,274.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	39,737,935.00	1,508,537.16	
413203	Түлш халаалтын өглөг	39,737,935.00	-	
413206	Шуудан холбооны өглөг	-	1,508,537.16	
41360	Бусад өглөг	97,268,277.50	60,567,077.50	
41361	Байгууллагад төлөх өглөг	97,268,277.50	60,567,077.50	
4	НИЙТ ОР ТӨЛБӨР (IV)	137,006,212.50	62,095,888.66	
51	Засгийн газрын хувь оролцоо	6,465,079,941.24	7,051,094,571.30	
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,378,300.73	613,378,300.73	
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	613,378,300.73	613,378,300.73	
51200	Хуримтлагдсан үр дүн	5,228,985,450.44	5,815,000,080.50	
51210	Өмнөх үеийн үр дүн	5,228,985,450.44	5,228,985,450.44	
51220	Тайлант үеийн үр дүн	-	586,014,630.06	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	622,716,190.07	622,716,190.07	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	6,465,079,941.24	7,051,094,571.30	

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	6,602,086,153.74	7,113,190,459.96
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,475,616,200.00	1,722,395,300.00
1310	Улсын төсвөөс	1,277,381,900.00	1,476,861,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,381,900.00	1,476,861,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	198,234,300.00	245,533,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	198,234,300.00	245,533,500.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	131,738,776.71	810,661,806.85
1200	Нийтлэг татварын бус орлого	131,738,776.71	810,661,806.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,569,984.00	12,535,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	16,569,984.00	7,535,200.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	108,856,577.67	748,715,088.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	6,312,215.04	49,411,518.52
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,607,354,976.71	2,533,057,106.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,640,747,204.27	1,936,129,810.13
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,593,469,937.27	1,858,583,010.94
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	926,961,357.00	1,126,066,388.00
210101	Үндсэн цалин	613,246,769.00	682,103,361.00
210102	Нэмэгдэл	261,272,548.00	337,019,763.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	34,155,000.00
210104	Урамшуулал	52,442,040.00	72,788,264.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,294,272.51	139,025,890.79
210201	Тэтгэврийн даатгал	77,916,449.51	95,106,270.10
210202	Тэтгэмжийн даатгал	9,335,419.00	11,169,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,999,942.00	5,857,727.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,642,059.00	4,724,778.69
210205	Эрүүл мэндийн даатгал	18,400,403.00	22,167,511.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,215,389.00	191,458,815.81
210301	Гэрэл, цахилгаан	10,906,763.00	11,250,189.81
210302	Түлш, халаалт	175,808,626.00	175,808,626.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,537,062.86	21,387,475.00
210402	Тээвэр, шатахуун	9,341,050.00	8,168,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,329,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,270,260.00	6,194,300.00
210408	Бараа материал акталсны зардал	6,925,752.86	5,695,375.00
2105	Нормативд зардал	35,003,870.00	48,010,970.00
210502	Хоол, хүнс	35,003,870.00	48,010,970.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,542,000.00	12,166,300.00
210604	Урсгал засвар	3,542,000.00	12,166,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,200,000.00	6,930,000.00
210702	Дотоод албан томилолт	3,200,000.00	6,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,238,209.59	14,737,537.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	964,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,238,209.59	13,773,537.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,477,776.31	298,799,634.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,758,687.40	14,907,302.94
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,651,200.00	7,459,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	256,067,888.91	276,432,631.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,277,267.00	77,546,799.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,158,330.00	76,422,350.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,341,930.00	62,638,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,816,400.00	13,783,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,118,937.00	1,124,449.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,118,937.00	1,124,449.19
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,640,747,204.27	1,936,129,810.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(33,392,227.56)	596,927,296.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	6,276,143.84	10,912,666.67
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,276,143.84	10,912,666.67
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	6,276,143.84	10,912,666.67
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(39,668,371.40)	586,014,630.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,475,616,200.00	1,722,395,300.00
1310	Улсын төсвөөс	1,277,381,900.00	1,476,861,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,381,900.00	1,476,861,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	198,234,300.00	245,533,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	198,234,300.00	245,533,500.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	16,569,984.00	12,535,200.00
1200	Нийтлэг татварын бус орлого	16,569,984.00	12,535,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,569,984.00	12,535,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	16,569,984.00	7,535,200.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	5,000,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,492,186,184.00	1,734,930,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,391,470,483.00	1,730,384,391.33
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,351,036,866.00	1,660,819,242.14
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	926,940,309.00	1,126,046,100.10
210101	Үндсэн цалин	613,225,721.00	682,103,347.10
210102	Нэмэгдэл	261,272,548.00	336,999,489.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	34,155,000.00
210104	Урамшуулал	52,442,040.00	72,788,264.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,315,320.51	139,025,904.69
210201	Тэтгэврийн даатгал	77,937,497.51	95,106,284.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,335,419.00	11,169,604.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,999,942.00	5,857,727.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,642,059.00	4,724,778.69
210205	Эрүүл мэндийн даатгал	18,400,403.00	22,167,511.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,215,363.00	231,196,750.81
210301	Гэрэл, цахилгаан	10,906,763.00	11,250,189.81
210302	Түлш, халаалт	175,808,600.00	215,546,561.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,400,000.00
2105	Нормативд зардал	33,407,930.00	47,934,670.00
210502	Хоол, хүнс	33,407,930.00	47,934,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,900,000.00	13,212,300.00
210604	Урсгал засвар	5,900,000.00	13,212,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,935,326.09	18,046,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,935,326.09	18,046,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,322,617.40	85,357,116.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,764,417.40	79,629,316.54
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,558,200.00	5,727,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,433,617.00	69,565,149.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,314,680.00	61,834,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,498,280.00	48,050,800.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,816,400.00	13,783,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,606,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,606,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,118,937.00	1,124,449.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,118,937.00	1,124,449.19
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,391,470,483.00	1,730,384,391.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	100,715,701.00	4,546,108.67
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,336,930.00	9,886,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	25,336,930.00	9,886,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,336,930.00	9,886,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,336,930.00	9,886,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(25,336,930.00)	(9,886,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	75,378,771.00	(5,339,891.33)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,900,577.61	137,279,348.61
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	130,279,348.61	131,939,457.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,378,300.73	622,716,190.07	5,261,653,821.84	6,497,748,312.64
Тайлант үеийн үр дүн	-	-	(39,668,371.40)	(39,668,371.40)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,378,300.73	622,716,190.07	5,228,985,450.44	6,465,079,941.24
Тайлант үеийн үр дүн	-	-	586,014,630.06	586,014,630.06
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	613,378,300.73	622,716,190.07	5,815,000,080.50	7,051,094,571.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татаас, санхүүжилтийн орлого	1,641,397,400.00	1,484,187,000.00	157,210,400.00
Улсын төсвөөс	1,632,197,400.00	1,476,861,800.00	155,335,600.00
Орон нутгийн төсвөөс	245,533,500.00	245,533,500.00	-
Тусламжийн орлого	9,200,000.00	7,325,200.00	1,874,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,886,930,900.00	1,729,720,500.00	157,210,400.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,410,010,000.00	1,265,072,004.69	144,937,995.31
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,342,100.00	1,126,046,100.00	127,296,000.00
Цалин	1,253,342,100.00	1,126,046,100.00	127,296,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	156,667,900.00	139,025,904.69	17,641,995.31
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	156,667,900.00	139,025,904.69	17,641,995.31
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	231,387,400.00	217,428,626.00	13,958,774.00
Тогтмол зардал	232,313,900.00	232,313,900.00	-
Гэрэл цахилгааны зардал	12,367,400.00	12,367,400.00	-
Түлш, халаалтын зардал	215,546,500.00	215,546,500.00	-
Цэвэр, бохир усны зардал	4,400,000.00	4,400,000.00	-

Хоол	53,430,800.00	47,934,670.00	5,496,130.00
Бусад бараа үйлчилгээний зардал	89,566,500.00	83,885,056.00	5,681,444.00
Шуудан холбооны зардал	16,753,400.00	18,046,400.00	-1,293,000.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,727,800.00	5,727,800.00	-
Урсгал засварын зардал	13,219,600.00	13,219,600.00	-
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	13,783,900.00	13,783,900.00	-
Бусад /үдийн цай/	52,125,000.00	48,050,800.00	4,074,200.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,886,930,900.00	1,728,034,130.69	158,896,769.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		130,253,088.87	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		131,939,457.28	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,472.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс тайлан үеийн ашигтай холбоотой 20.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,452.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 20.2 мянган төгрөгийн 1 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайланд тайланд үеийн ашгийг 20.2 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Насжилт өндөртэй 559.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т (*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*), 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6.-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байг уулах, удирдах*) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээг авч, тооцоо нийж баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас 1,892.9 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), Засгийн газрын 2025 оны 254 дугаар тогтоол 2-т (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай*) гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэх, хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 21 ширхэг хөрөнгийн коджуулалт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*), 20 дугаар зүйлийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*;) заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн ашиглалт хадгалалтад хяналт тавьж ажиллах, хөрөнгийн коджуулалт хийх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн нийт 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (*Шилэн дансны зарчим*), 4.1.1-д (*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*);, 4.1.3-т (*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*);, 6 дугаар зүйлийн 6.4-т (*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*);, 6.4.8-д (*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*);, 7.2 -т (*Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй*.) гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж ажиллах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 99.1 хувийг залруулагдаагүй, 0.9 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 2,452.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,452.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 16,888.4 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд тайлант үеийн ашгийг дутуу тайлагнасан.	1	20.2	-	-	1	20.2	1	20.2	-	-	-	-
Дүн	1	20.2	-	-	1	20.2	1	20.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Насжилт өндөртэй барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	559.7	-	-	1	559.7	-	-	-	-
Сургуулийн хүнсний материалын тайлангаас зарлагын баримт, хоолны ордерыг тулгаж шалгахад хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, Дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас илүү дүнгээр зарцуулсан байна.	1	1,892.9	-	-	1	1,892.9	-	-	-	-
Дүн	2	2,452.6	-	-	2	2,452.6	-	-	-	-